

(албан бус орчуулга)

Япон улсын Засгийн газар болон Монгол улсын Засгийн газар хоорондын
хамтын ажиллагааны санамж бичиг

(Товч агуулга)

1. Талууд, эдийн засгийн нягт харилцааг хөгжүүлэх зорилготойгоор энэхүү хамтын ажиллагааны санамж бичгийг үйлдсэнээр хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг дахин нотлох нь хоёр орны эрх ашигт нийцнэ хэмээн талууд санал нэгдсэн байна.
2. Талууд, дараах зүйлийг стратегийн ач холбогдолтой болохыг нотоллоо. Үүнд:
 - (1) Япон улсын аж ахуйн нэгж өөрийн сонирхолд тулгуурлан Монголын дэд бүтцийн төсөлд оролцох
 - (2) Япон улсын аж ахуйн нэгжийн Монгол улсад хөрөнгө оруулах боломжийг нэмэгдүүлэх
 - (3) Тогтвортой ханган нийлүүлэлт, эдийн засгийн ашиг, үр өгөөжийн үүднээс Япон улсын хувьд нэн чухал байгалийн баялгийг хангах эх үүсвэрийг төрөлжүүлэх
 - (4) Монгол улс болон (эсвэл) гуравдагч орны нүүрсний үр ашигтай хэрэглээг дэмжих
3. Талууд, Японы аж ахуйн нэгж хөрөнгийн оролцоо бий болгох зэрэг тохиолдолд доорхи чиглэлээр мэдээлэл болон санал солилцоно.
 - (1) Японы аж ахуйн нэгж маркетингийн компанид шууд хөрөнгийн оролцоо бий болгох замаар Монголын нэн чухал байгалийн баялаг (Тавантолгойн уурхай зэрэг)-ийг хөгжүүлэх
 - (2) Монголын нүүрсийг үр ашигтай ашиглах болон Япон улс руу тээвэрлэх
 - (3) Зүүн чиглэлийн төмөр замын ажлын үр ашгийг тодорхойлохын тулд, жишээлбэл, Япон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/-наас хэрэгжүүлэх боломжтой судалгаа
 - (4) Тавантолгойн уурхайг хөгжүүлэхтэй холбоотойгоор процедурын ил тод байдал, тууштай байдал, урьдчилан таамаглах боломжоор хангах

Жич: Энэхүү хамтын ажиллагааны санамж бичгийг хууль, эрхзүйн үр дагавар үүсгэх баримт бичиг хэмээн үзэхгүй бөгөөд аль нэг талд хууль, эрхзүйн аливаа үүрэг хариуцлагыг үүрүүлэх утга санааг агуулаагүй болно.